

МОНГОЛ УЛСАД ГЭРЭЛ ЗУРГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР
ТӨРӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Ц.Батбаатар*

* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант

Түлхүүр үгс: фото сэтгүүл зүй, зураг үйлдэгч, түүхэн фото, цахилгаан сүүдэр, зурагчин

1 921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялснаар Монгол Улсад хөгжлийн нэгэн шинэ үе эхэлж, Ардын засгийн газраас боловсрол, соёлыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч эхэлсэн байна. Тэдгээрийн нэг нь гэрэл зургийг хөгжүүлэхтэй холбоотой шийдвэрүүд байжээ.

1920-иод оны үед Нийслэл хүрээнд өөрийн сонирхлоор гэрэл зураг авдаг хүмүүс нэлээд байжээ. Тэд ямар нэг журам дүрэмд захирагдахгүй, цэвэр өөрсдийн сонирхол, хүсэл зоригоор ажиллаж байсан аж. Харин Монгол Улсад Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанаар эдгээр хүмүүсийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулсан байдаг.

Судар бичгийн хүрээлэнгийн 12 дугаар хурлын тогтоолд "...Олноо өргөгдсөний Арван хоёрдугаар /1922/ он, есөн сарын шинийн хоёр бөгөөд аргын улирлын 10 сарын 22-нд арван хоёрдугаар удаа хуралдаж хэлэлцэн тогтсон нь: Нэгдүгээр зүйл. Зураг үйлдэгч эрдэмт орос Лисовскийн биеийг цахилгаан тэргэнд суулгаж, зураг

үйлдэхэд хэрэгсэх аливаа бодисын байдал дүрсийн хэв, будаг, цаас худалдан авах хэргээр Бээжин, Тянжин зэрэг газар илгээх ба замын хэрэгсэл, худалдан авах юмны үнэ зэрэгт төсөвлөн 400 лан олгож явуулахаар тогтов" хэмээжээ. Үүнээс үзэхэд төрөөс гэрэл зургийг хөгжүүлэх, гэрэл зурагчдыг хэрэглэх материалаар хангах талаар онцгой анхаарч байсан нь тодорхой байна. Бид энэхүү өгүүллээрээ төр засгаас тэр үед ямар чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар тухайлан авч үзэх болно.

1920-иод он бол Монгол Улсад шинэ социалист хэвлэл үүсэн хөгжиж асан үе юм. Энэ үед төр засгийн харьяанд мэдээллийн зарим хэрэгслийг үүсгэн байгуулж, түүний үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулж байсан билээ. Үүнд гэрэл зургийн асуудал ч бас хамаатай байсан нь тэр үед авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээнээс тодорхой байдаг. Тухайлбал, Монгол Улс 16 (1926) дугаар оны 1 дүгээр сарын 11-нд хуралдсан анхдугаар хурлын тогтоолдоо "Нэгдүгээр зүйл. Орос эрдэмтэн Кондратьевын биеийг харьяат хүрээлэнгийн орон тоон дор урьд баталсан Европ зүгийн боловсон зурагчинд томилон авч энэ сарын арван зургаа-

наас эхлэн албан хаалгахаар хэлэлцэн тогтов” хэмээсэн зэргээс харж болно.

“Манай зам” сэтгүүлийн 1923 он буюу Олноо өргөгдсөний 13 дугаар оны нэгдүгээр сард гэрэл зургийн тухай МХЗЭ-ийн Төв Хорооны тогтоол гарсан байна. 1923 оны 7 дугаар сарын 18-ны өдөр хуралдсан Бүх Монголын хувьсгалт залуучуудын төлөөлөгч нарын хоёрдугаар их хурлын тогтоолд өгүүлэхдээ, “тус эвлэлийн гишүүдээс ухаан сэргэлэн хэдэн хүнийг зураг авах ба цахилгаан сүүдэр гаргах сургуульд боловсруулан зураг авах, цахилгаан сүүдэр гаргах зэрэг ажил хийлгэвээс орлоготой болохоор үл барам эрдмийн зүйлд холбогдоно” (Бүх Монголын хувьсгалт залуучуудын төлөөлөгч нарын хоёрдугаар их хурлын тогтоол, 1923) хэмээсэн байдаг.

Ардын Засгийн газраас гэрэл зураг, зурагчинтай холбоотой асуудлыг хянан шийдвэрлэхийг Дотоодыг хамгаалах газарт зааварласны үндсэн дээр 1928 оны 6 дугаар сард “Цахилгаан сүүдрийн зэрэг зураг буулган авах явдлыг хэрхэн яахан хянан харилцваас зохих явдлыг тодорхойлсон заавар”-ыг 11 зүйлтэй батлан гаргаж мөрдүүлсэн байна.

Үүний дараагаас эхлэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1931 оны 11 дүгээр сарын 1-нд “Кино үйлдвэр байгуулах тухай” тогтоол гаргаж, 1932 оны эхэн үеэс кино, гэрэл зургийн газар байгуулахад анхаарч эхэлжээ.

Улмаар Сайд нарын Зөвлөлийн 1935 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар хурлаар Монголд “Кино, гэрэл зургийн газар”-ыг байгуулах асуудлыг тусгайлан хэлэлцэж, “Тус улсын үндэсний байдлыг үзүүлэн гаргаж байх кино, гэрэл зургийн

үйлдвэрийг үүсгэн байгуулбал зохино” гэснээр Монгол Улсад баримтат кино, гэрэл зургийн алба албан ёсоор байгуулагдсан түүхтэй.

Ардыг гэгээрүүлэх яамнаас төлөвлөн оруулсны дагуу Сайд нарын Зөвлөлийн 1936 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 40 дүгээр хурал болон Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 44 дүгээр хурлаар “Монгол кино зургийн хорооны дүрэм”-ийг батлан харьяа салбаруудын эрхлэн гүйцэтгэх ажлуудыг зааж өгчээ.

Энэ дүрмийн хоёрдугаар зүйлд: “Монголын кино зургийн хороо нь кино зураг хийх үйлдвэрийг байгуулж, түүнд холбогдох ба соёл боловсрол, мөн уран сайхны зургуудыг үйлдэж гаргах, тус улсын дотор зургийг хөлсөөр хэрэглэх, бүхий л дуутай ба дуугүй нэгтгэлийн кино зургуудын ажлыг зохион байгуулах, кино театруудыг шинээр нээн байгуулах, зургийн ажлыг нээн байгуулж тухайн төлөвлөгөөгөөр зургуудыг гаргах, мөн түүнчлэн кино, зургийн бүх мэргэжлийн шинэ хүчнийг бэлтгэж, эдгээр ажлаар өөрийн зорилгыг биелүүлнэ” (Монгол кино зургийн хорооны дүрэм, 1936.) гэж заасан байна.

Мөн дүрэмд “Монгол кино зургийн хорооны дотор байваас зохих салбаруудыг нь олон нийтээр хэрэглэгдэх зургийг авах салбар” болно гээд Кино зургийн хороо ба түүний харьяа салбаруудын эрхлэн гүйцэтгэх ажлуудыг тодорхойлсон байдаг. Үүнд: “...Хүний зургийг авч худалдаалах газрын ажил үүргийг гагцхүү Улсын кино зургийн хорооноос эрхлэн салбарыг нээн байгуулж, олон нийтээр хэрэглэх зургуудыг гаргах албан байгууллага ба энгийн этгээдийн захиалгыг гүйцэтгэх, “Улсын кино зургийн хороо”-нд өөрийн үйлдвэрээс боловсруулсан тус орны

соёл боловсрол, аж ахуй ба уран сайхны талаар үйлдвэрлэгдсэн зургуудаас заримыг нь Засгийн газрын зөвшөөрлийн ёсоор худалдааны байгууллагатай харилцаж гадаадад гаргаж худалдаалах эрхтэй болно” гэх мэтээр зааж өгчээ.

Улсын гэрэл зургийн газрыг хөгжүүлэхэд анхаарч, Шинжлэх ухааны хүрээлэнгийн фото зургийн тасагт ажиллаж байсан Бадамыг мэргэжлийн дагуу Улсын кино зургийн хороонд нэн даруй шилжүүлэн өгөхийг тус хүрээлэнд даалгасан нь нэр зааж өгсөн гэрэл зургийн ганц мэргэжилтэн болж, 1935 оны 10 дугаар сараас Улсын кино зургийн хороонд шилжин ажиллаж байжээ.

Ийнхүү Монгол Улсад гэрэл зураг сонирхогчид, курс дугуйлангаар гэрэл зурагчдыг бэлтгэж, тэдний тоо олшрохын хэрээр зохиогчийн эрхийн асуудал тодорхой хэмжээнд яригдах болсон байна. Энэ дагуу БНМАУ-ын Ерөнхий сайдын 149 тоот тушаал 1935 онд гарчээ. Уг тушаалд *“...ямар нэг тусгай зохиолууд ба гэрэл зургийн зүйлийг бусад албан яамд ба олон нийтийн газраас бичиг сэтгүүлд оруулан хэвлэхэд зохиогч буюу газраас урьдаар зөвшөөрлийг авч, түүний нэрийг оролцуулан хэвлэх”* (БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хуулиуд хийгээд, тушаалуудыг эмхэтгэн хавсарсан сэтгүүл., 1935, хуудсд. 758-759) тухай зааж, зохиогчийн эрхийг нарийн тодорхой ялгаж хуульд тусгаж оруулахыг Шүүх яаманд даалгасан байна. Энэ нь зохиогчийн эрхтэй холбоотой анхны шийдвэр байсан гэж үзэж болохоор байна.

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1939 оны 5 дугаар сарын 30-

ны өдрийн 76 дугаар хурлаар “Улаанбаатар хот ба зарим том аймгуудын төвд улсын фото гэрэл зургийн газрыг байгуулж, фото зургийн эрэлтийг хангах, ингэхийн тулд 8 сарын дотор 5-6 аймагт зураг авах газар байгуулж дуусгах, 1940 онд Улаанбаатар хотод шинэ үлгэр жишээ бүхий том гэрэл зургийн газар байгуулах” тухай хэлэлцэж Уран сайхны хүрээлэнд үүрэг болгож байжээ.

Үүний зэрэгцээ Шинжлэх ухааны хүрээлэнгийн фото зургийн газар ба кино зургийн газруудын хүчийг хавсарган нэгтгэх тухай боловсруулан хянаж гүйцэтгэхийг Шинжлэх ухаан ба Уран сайхны хүрээлэнд даалгажээ (МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэр (1921-1966)., 1967).

Мөн 1940 оны 4 дүгээр сард хуралдсан МАХН-ын X их хурлаас аймаг болгонд гэрэл зургийн салбар байгуулахаар тогтоол гаргаж, олон нийтийн фото зургуудын яс чанарыг сайжруулан үнийг хямдруулах явдлыг Хүрээлэн ба Монгол кино зургийн хороонд даалгасан байна. Ийнхүү 1940 оны сүүлчээс эхлэн аймаг, орон нутгийн хэмжээнд гэрэл зургийн салбарууд үүсгэн байгуулагджээ.

Дээрх хурлаас Шинжлэх ухааны хүрээлэнгийн Гэрэл зургийн газар ба Кино зургийн газрыг нэгтгэх ажлыг хянаж гүйцэтгэхийг Шинжлэх ухаан ба Уран сайхны хүрээлэнд даалгаснаар 1939 онд Кино, зургийн хорооны гэрэл зургийн тасаг нь Төвийн гэрэл зургийн газар болон өргөжиж “гавьяаны” болон “энгийн” гэсэн хоёр тасагтайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй.

Намын Төв хорооны Улс төрийн товчооны 1947 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар “Утга зохиол, урлаг, хэвлэл мэдээллийн хэрэгслийн

бүтээлд хэрхэн хяналт тавих тухай” асуудлыг хэлэлцээд БНМАУ-д хэвлэгдэж байгаа бүх хэвлэл, радио нэвтрүүлэг, урлагийн газраас үзүүлэх зүйлд улсаас хяналт тавих үүрэг бүхий Утга зохиол ба хэвлэлийг хянах ерөнхий газрыг Сайд нарын Зөвлөлийн дэргэд байгуулахаар тогтжээ.

Тус газрын дүрмийн нэгдүгээр зүйлд “Хэвлэх буюу гараар бичиг нийтлэх, тараах тогтмол ба тогтмол биш бүх хэвлэл, газрын зураг, гар зураг, фото зураг зэргийг урьдчилан хянаж үзэх” тухай заажээ. Үүнтэй холбоотойгоор тухайн үед хэвлэгдэж байсан сонин сэтгүүлд гарч байгаа нийтлэлийн агуулга төдийгүй, гэрэл зурагт хяналт тавих болсон байна.

Энэ тогтоолын дагуу гэрэл зургийн чанарыг сайжруулах, үнийг хямдруулах, гэрэл зургийн сониныг онц сонирхолтой, чанартай хийх, дугаар бүрийн товье төлөвлөгөөг гаргах, захиалгыг нэмэгдүүлэх, сайн дураар зураг авдаг хүмүүсийг бүртгэх, тэднээс бүрдсэн зураг авагчдын бүлгэм байгуулах, авсан зургаар нь төв клубүүдийг ашиглан гэрэл зургаар үзэсгэлэн байгуулах зэрэгт анхаарч ажиллахыг үүрэг болгосон байна.

МАХН-ын XI их хурлаар 1948-1952 онуудад БНМАУ-ын ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөг баталж, урлагийн газруудыг цаашид хөгжүүлэн 1952 онд улсын хэмжээнд 46 гэрэл зургийн газар байгуулах зорилт

дэвшүүлж, хөдөлмөрчдийн амьдрал ба соёлын хэмжээг дээшлүүлэх төлөвлөгөөг баталсан тогтоол гаргасан байна.

Тухайлбал, Урлагийн хэргийг эрхлэх хорооны дарга Болодоос 1951 оны 10 дугаар сард Намын Төв хороонд “Фото зургийн салбарууд нэмэгдсээр одоо аймаг бүрд 1-2 болжээ. Тэдгээр нь зөвхөн хүмүүсийн зураг авах үүрэгтэй ажиллаж байна. Төв гэрэл зургийн газраас хот-хөдөөгийн салбаруудыг удирдах байтугай өөрийн бүтээж буй зургийн чанарыг сайжруулж чадахгүй байна. Нөгөө талаас зөвхөн хүмүүсийн зураг авдаг гэрэл зургийн салбарууд нь зохион байгуулалтын хувиар аймаг-хотын бага хурлуудад үсчин, халуун ус мэт харьяалагдаж байх ёстой юм. Ийм учраас хот-хөдөөгийн гэрэл зургийн салбар байгууллагуудыг аймаг-хотын бага хурлын мэдэлд шилжүүлэх шийдвэр өгнө үү. Урлагийн хэргийг эрхлэх хорооны харьяанд уран сайхны фотогийн ажил эрхэлдэг гэрэл зургийн студи байж болох юм” (Улс төрийн, нам олон нийтийн байгууллагын баримтын архив, 1923) хэмээн нам засгаас урлагийн ажлыг сайжруулах талаар тавих ээлжит зорилготой уялдуулан санал төлөвлөж илтгэх хуудас хүргүүлж байжээ.

Улсын гэрэл зургийн газрын 1951 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгажээ. Үүнд:

Хүснэгт 1.

№	Ажлын нэр	1951 он төлөвлөгөө	Одоо буй	Тайлбар
1	Хотын салбар	9	4	Хотод 5 хятад салбар бий
2	Хөдөө салбар	32	25 -27	
3	Зурагчин хотод	15	12	
4	Мөн хөдөөд	50	49	
5	Лаборант	8	8	

1952 оны 5 дугаар сарын 27-нд БНМАУ-ын Иргэний шинэ хуулийг батлан гаргасан. Энэ хуульд гэрэл зургийн зохиогчийн эрхтэй холбоотой заалтыг илүү дэлгэрэнгүй тусгажээ. Энэ хуулийн Зохиогчийн эрхийн тухай 18 бүлгийн 274 зүйлд “Гэрэл зургийн бүтээлүүдийг анх гаргасан өдрөөс эхлэн 5 жилийн турш зохиогч ба түүний эрхийг залгамжлагчид өмчлөх эрхтэй. Дурдсан хугацаанаас хойш зохиогчийн эрх улсад шилжинэ”, 276 зүйлд “гэрэл зургийн бүтээлийг зохиогчийн эрхийг хамгаалахын тулд бүх хувиуд дээр зохиогчийн нэр, гаргасан оныг заавал тэмдэглэсэн байх ёстой” гэх мэтээр зааж өгчээ. Мөн тус хуулийг 1963 онд шинэчлэн батлахдаа түүнд гэрэл зургийн зохиогчийн эрхийн тухай зүйлийг дахин оруулсан байдаг.

Манай оронд 1930-аад оны дунд үеэс гэрэл зураг мэдээллийн хэрэгслийн сэтгүүл зүйн үйл ажиллагааны төрөл болох чиглэлээр хөгжиж, “Үнэн”, “Ардын үндэсний эрх”, “Улаан од” зэрэг төвийн хэвлэлүүдэд М.Гомбажав, Б.Чойжинням, Ц.Дагдандорж зэрэг манай ууган гэрэл зурагчдын гэрэл зураг, фото мэдээ, сурвалжилга, хөрөг тогтмол гарах болсон байна. 1970-аад он гэхэд фото зураг, фото сурвалжилга сэтгүүл зүйн төрөл зүйл болж жигдрэн төлөвшсөн байна.

Сонин, сэтгүүлийн газрууд ба гэрэл зургийн үзэсгэлэнг сайн чанарын зургаар хангах, тус орны хөгжил, хүмүүсийн амьдралыг өөрийн орны ба бусад орны ард түмэнд гэрэл зургаар сурталчлах ажлыг сайжруулах, зурагчдын хүчийг зөв хуваарилж төвлөрүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, хөдөлмөр ба материалыг хэмнэх зорилгоор Сайд нарын Зөвлөлөөс 1956 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “Гэрэл

зургийн мэдээллийн ажлыг сайжруулах арга хэмжээний тухай” 248 дугаар (Улс төрийн, нам олон нийтийн байгууллагын баримтын архив, 1956) тогтоолыг батлан гаргажээ.

Энэ тогтоолоор Гэрэл зургийн мэдээлэл эрхлэх тасгийг хар цагаан зургийн лаборатори, өнгөт зургийн лаборатори, үзэсгэлэн чимэглэл үйлдвэрлэх тасаг, гэрэл зургийн архив гэсэн тасагтай байгуулж, сонин, сэтгүүлийн

газрууд ба улс, олон нийтийн байгууллагуудыг хэрэгцээт зургийн материалаар саадгүй хангахаас гадна гадаадад гаргах гэрэл зургийн үзэсгэлэн ба бусад гэрэл зургийн материалыг боловсруулан гаргах ажлыг төв студид хариуцуулжээ.

Зурагч-сурвалжлагчдын мэргэжлийг дээшлүүлэхийн тулд тэдний дунд техникийн хичээлийг тогтмол явуулах, цаг үеийн холбогдолтой өөрийн орны болон гадаад улс орны



Манай оронд 1930-аад оны дунд үеэс гэрэл зураг мэдээллийн хэрэгслийн сэтгүүл зүйн үйл ажиллагааны төрөл болох чиглэлээр хөгжиж, “Үнэн”, “Ардын үндэсний эрх”, “Улаан од” зэрэг төвийн хэвлэлүүдэд М.Гомбажав, Б.Чойжинням, Ц.Дагдандорж зэрэг манай ууган гэрэл зурагчдын гэрэл зураг, фото мэдээ, сурвалжилга, хөрөг тогтмол гарах болсон байна. 1970-аад он гэхэд фото зураг, фото сурвалжилга сэтгүүл зүйн төрөл зүйл болж жигдрэн төлөвшсөн байна



тухай танилцуулсан гэрэл зургийн мэдээллийг тогтмол гаргах, гэрэл зургийн ажлыг хөгжүүлж, авьяастныг төрүүлэхийн тулд сайн дурын зурагчдын дунд уран сайхны гэрэл зургийн уралдааныг үе үе зарлан явуулахыг дээрх тогтоолоор зохицуулж өгсөн нь ихээхэн чухал байв.

Мөн энэ тогтоолоор ард иргэдийг гэрэл зургаар үйлчлэх нийтийн үйлчилгээний гэрэл зургийн салбаруудыг аймаг, хотын гүйцэтгэх захиргааны мэдэлд шилжүүлжээ.

Сонин, сэтгүүлийн фото зургийг сайжруулах, фото зурагчдын ажлыг нэгдмэл ажиллагаагаар хангахын тулд МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1956 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 170 дугаар тогтоолоор “Сонин сэтгүүлийн фото зурагчдыг нэгтгэх тухай” шийдвэрийг гаргаж, төсөв, журмыг баталсан байна (Улс төрийн, нам олон нийтийн байгууллагын баримтын архив, 1956).

Журамд зааснаар “Хөдөлмөр”, “Залуучууд”, “Улаанбаатарын мэдээ”, “Үнэн” сонин, “Туяа” сэтгүүлийн зурагчдыг нэгтгэж Монголын сонин, сэтгүүлийн дэргэд фото сурвалжлагчдын товчоо ажиллуулахаар зааж, товчооны бүрэлдэхүүнд ахлагч-1, зурагчин-4, зурагчин тус бүр сар тутам 750 төгрөг, ахлагч 800 төгрөгийн цалинтай байх, сар тутам гарах сонин, 2 сар тутам орос хэл дээр гарах сэтгүүл зэрэг бүгд 66 удаагийн сонинд 143 зураг бэлтгэн өгч байх үүргийг тодорхой зааж өгчээ.

Энэхүү тогтоолын шийдвэрт бас нэг чухал заалт оржээ. Монголын түүхэнд холбогдох гэрэл зургуудаас шилдэг 20 зургийг сар бүр шалгаруулж, Зөвлөлт Холбоот Улсын ТАСС-ын газар ба ардын ардчилсан орнуудад явуулах болсон нь Монгол Улсыг

сурталчлахад онцгой ач холбогдолтой болжээ.

Гэрэл зургийн салбарын ажиллагаа жилээс жилд сайжирч иржээ. Тухайлбал, Ховд аймгийн гэрэл зургийн салбар 1956 онд төлөвлөгөөгөө 133,6%-иар биелүүлсний дотор салбарын эрхлэгч Хүүхлээ, зурагчин Даваажав, Хаш, Лэгжмаа нар сайн ажиллаж, хөдөө аж ахуйн нэгдлийн амьдрал, үйл ажиллагаа, аймгийнхаа хөгжилтийг харуулсан гэрэл зургийн самбар, үзэсгэлэн гаргаж байжээ.

Гэрэл зургийн газрыг өргөтөхийн зэрэгцээ үйл ажиллагааг нь нийтэд хүргэх зорилгоор Сайд нарын Зөвлөлөөс 1960 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 118 дугаар тогтоол гаргаж, Гэрэл зургийн газарт хар, цагаан ба өнгөт зургийн томоохон лаборатори байгуулсан байна.

Хэдийгээр гэрэл зургийн салбарын үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж, гэрэл зурагчдын бүтээл сайжирч байсан ч, зарим гэрэл зургийг намын үзэл суртал, тухайн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хэвлэхийг хориглох, устгах тохиолдол гарч байжээ. Тухайлбал, Чингис хааны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар МАХН-ын Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнөөс 1962 оны 10 дугаар сард “Орчин үеийн Монгол” сэтгүүлийн 1962 оны 6 ба 7 дахь дугаарын тухай” тогтоол гаргажээ. Уг тогтоолд “Орчин үеийн Монгол” сэтгүүлийн 1962 оны 6 дахь дугаарт Чингисийн 800 жилийн ойтой холбогдуулан бичсэн өгүүлэл ба мөн сэтгүүлийн 7 дахь дугаарт нийтлэгдэхээр бэлтгэгдсэн гэрэл зураг нь намын бодлогод нийцэхгүй учир” хүчингүй болгосон тухай заажээ.

Тухайн сэтгүүлд ямар гэрэл зураг хэвлэгдсэн, чухам хэний бүтээл

хураагдаж, устгасныг өнөө бид хараахан мэдэх боломжгүй байгаа юм. Тэр сэтгүүлийн дугаар ч хадгалагдсангүй. Тус сэтгүүлийг Улсын төв номын сан, Улсын төв архив, Стратеги академийн номын сан зэрэг томоохон номын сангийн сан хөмрөгт хайж үзсэн боловч тэнд үр дүнд хүрсэнгүй. Цаашид судлаачид, гэрэл зураг сонирхогчид энэ талаар судалж, тэр сэтгүүлийн үндсэн эхийг олж үзэж судалгааны эргэлтэд оруулах буй за.

Монгол Улсад гэрэл зургийн алба байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гэрэл зургийн нийт байгууллагын орон тоо, цалин, ажлын норм, тариф, үнэ хөлсний талаар нэгдсэн журам байхгүй, мэргэжилтэн дутмаг, зургийн өнгө үзэмж чанаргүй байгаа зэргийг харгалзан цаашид эдгээр ажлыг сайжруулах зорилгоор Сайд нарын Зөвлөлөөс 1963 оны 10 дугаар сарын 9-нд “Гэрэл зургийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” (Гэгээрэл, шинжлэх ухаан, соёлын талаар холбогдолтой хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл (1961-1963), 1964, хуудсд. 262-263) 470 тоот тогтоол гаргажээ.

Уг тогтоолд “...Гэрэл зургийн зорилго бол манай орны байдал, улс ардын аж ахуй, соёлын байгуулалтад олж байгаа ололт амжилт, ард түмний аж амьдралын дээшлэлтийг бодит үнэний үндсэн яруу сайхнаар сурталчлахын хамт хөдөлмөрчдийг гуа сайхнаар үйлчлэх явдал мөн” гэж заажээ.

Гэрэл зургийн төв студи болон нийт гэрэл зургийн газруудыг боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, бусад хэрэгцээт зүйлээр хангаж байх, тэдгээрийн ажиллагаанд аргачилсан заавар зөвлөгөө өгөх, гэрэл зургийн дунд ба дээд мэргэжилтэй боловсон хүчнийг дотоод, гадаадад сургууль,

курс, практикийн журмаар бэлтгэх, гэрэл зургийн ажлыг одоогийн шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулж, албан байгууллага, хөдөлмөрчдийн хэрэгцээний гэрэл зургийн үзэл суртал, уран сайхны чанарыг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахыг Гадаад худалдааны яам, Соёлын яаманд үүрэг болгожээ.

Мөн гэрэл зураг сонирхогчдын идэвхийг өрнүүлэн, гэрэл зургийн шилдэг сайн бүтээлийг бий болгох зорилгоор Соёлын яамны дэргэд гэрэл зурагчдын нийгэмлэг байгуулж, түүний ажлыг тодорхой удирдлагаар хангах, сайн чанарын гэрэл зургийг элбэгжүүлэхийн тулд уралдаан зарлах, гэрэл зургийн газрын ажиллагаанд аж ахуйн тооцооны зарчмыг нэвтрүүлж, бүртгэл тооцооны ажлыг сайжруулах, гэрэл зургийн үзэсгэлэн, самбар зэрэгт зориулсан гэрэл зургийн үнийг 1963 онд багтаан нэгдсэн үнэ тогтоох зэрэг арга хэмжээг тусгаж өгчээ.

Намын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас гэрэл зургийн ажлыг сайжруулах, олон нийтэд сурталчлах зэрэг тогтоол шийдвэрүүд удаа гаргаж байсны дээр гэрэл зургийн фондыг баяжуулах, негатив, сэтгүүл, сонинд шилжүүлэх, хроникд явуулах зургийн утга агуулга, чанарыг сайжруулах зорилгоор 1971 онд “Гэрэл зургийн редакцад мэргэжлийн комисс байгуулах тухай” тогтоолыг Мэдээлэл, радио, телевизийн улсын хорооноос гаргасан нь гэрэл зургийн негативыг бүрдүүлэхэд чухал алхам болжээ.

МАХН-ын ХҮИИ их хурал, Ардын хувьсгалын 55 жилийн ойг угтаж, Соёлын яам, Монголын сэтгүүлчдийн холбоо хамтран аймаг хотын гэрэл зургийн салбар, студи, сонин хэвлэ-

лийн бүх зурагчдын дунд гэрэл зургийн уралдаан зарласан нь гэрэл зурагчид, уран бүтээлчдийн уран чадвар, идэвх санаачилгыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон байна.

Гэрэл зурагчид болон сонирхогчдод зориулан гэрэл зураг авах тухай ном орчуулан гаргаж, түүнчлэн “Соёл” сэтгүүл дээр цувралаар “Гэрэл зураг сонирхогчдод тусламж”, “Гэрэл зургийг гэрэл шүүгчийн тусламжтайгаар гуа сайхан авч суръя”, “Гэрэл зургийн уран сайханд анхааръя” зэрэг нийтлэлийг цувралаар гаргах болжээ.

Соёлын тэргүүний ажилтны улсын II зөвлөгөөн 1977 оны 11 сард Улаанбаатар хотноо хуралдахад “Гэрэл зурагчид аа. Гэрэл зургийн бүтээлээр эх орныхоо хөгжлийг сурталчилж хүн ардыг хүмүүжүүлэх үйлсдээ их амжилт олохын тулд гэрэл зурагчин бүр мэдлэг мэргэжлээ цуцалтгүй дээшлүүлж, зургийн техник хэрэгслийг чадамгай эзэмшин шилдэг бүтээлээр урын сангаа баяжуулъя. Гэрэл зурагчин бүр зургийн зохиомж, агуулга, чанар, уран сайхны чадлыг сайжруулах, өнгөт гэрэл зургийг хөгжүүлэх, гэрэл зургийн төрөл зүйл, тодорхой сэдвийн дагуу, үзэсгэлэн, санал солилцох уулзалт өргөн зохиож байх ажилд ихээхэн анхаарал тавьж ажиллая” хэмээн уриалсан байна.

Соёлын яам, Монголын сэтгүүлчдийн холбоо хамтран 1975 онд зарласан гэрэл зургийн уралдаанд 30-аад гэрэл зурагчдын 200 шахам бүтээл, 1976 онд 50 гаруй гэрэл зурагчдын 500 орчим бүтээл ирж, аймаг, хотын гэрэл зургийн салбар студи, редакцаас ирүүлсэн бүтээлийг нийтэд нь үзэсгэлэн болгон үзүүлэн, шалгаруулахад Өвөрхангай аймгийн

гэрэл зургийн салбар I байр, Дархан хотын гэрэл зургийн газар II байр, Дундговь аймгийн гэрэл зургийн газар III байр тус тус эзэлжээ. Тус уралдаанд Улаанбаатар хотын гэрэл зургийн студи, сонин хэвлэлийн редакц, Говь-Алтай, Дорноговь, Сүхбаатар аймгийн гэрэл зургийн газрууд оролцоогүй байна (Х.Дамдин, 1977, хууд. 13).

Гэрэл зургийн уралдаан нь зөвхөн байр эзлүүлж, шагнал олгох төдий биш гэрэл зурагчдын ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэх, гэрэл зургийн урлагийн хөгжлийн түвшин, хойшид авах арга хэмжээний тухай дүн шинжилгээ хийх, мэргэжлийн төдийгүй гэрэл зураг сонирхогч бүрийг уралдаанд оролцуулах боломжийг олгосон зэрэг олон талын ач холбогдолтой байв.

Соёлын яам, Мэдээлэл радио, телевизийн улсын хорооны саналыг үндэслэн Сайд нарын зөвлөлөөс 1978 оны 1 дүгээр сард “Гэрэл зургийн газруудын зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 436 дугаар тогтоол гаргажээ. Энэ тогтоолоор Сайд нарын Зөвлөлийн “Гэрэл зургийн мэдээллийн ажлыг сайжруулах арга хэмжээний тухай” 1956 оны 248 дугаар тогтоолын “а”, “г” заалт, 1972 оны “Зарим байгууллагын нэрийг өөрчлөх тухай” 15 дугаар тогтоолоор баталсан Гэрэл зургийн төв студийг “Улсын гэрэл зургийн газар” гэсэн хэсгүүдийг хүчингүй болгосон юм.

Гэрэл зургийн газар, редакцыг нэгтгэсэнтэй холбогдуулан уран сайхны гэрэл зургийг хөгжүүлэх, мэдээлэл, самбар, үзэсгэлэн бэлтгэх, гэрэл зураг сонирхогчдын дунд уралдаан зохион байгуулах зэрэг үүргийг Мэдээлэл радио, телевизийн улсын хороонд хариуцуулсан байдаг.

Түүнчлэн соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах тусгай хууль, эрх зүйн баримт бичгүүдийг 1920-иод оноос батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 1970 онд Сайд нарын Зөвлөлөөс БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг батлан гаргажээ. Уг хуулийн соёлын дурсгалт зүйл гэдэгт "...соёлын түүх, дурсгалын холбогдолтой гэрэл зураг, соронзон хальс, пянз, кино зургийн хальс зэрэг зүйлс" гэж оруулсан нь гэрэл зургийг соёлын өвд хамруулах тухай анхны хуульчилсан акт болсон гэж үзэж болно.

Монгол Улсын Засгийн газраас 1994 онд Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль баталжээ. Тэрчлэн 2001 онд баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар бүлгийн 1.4-т Түүх соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад "сурвалж бичиг, гар бичмэл, барын болон хэвлэмэл ном судар, аман зохиол зэрэг бичгийн дурсгал, гэрэл зураг, кино болон дүрс бичлэг багтана" гэж заасан нь гэрэл зургийг түүхэн дурсгалт зүйлийн үнэ цэнийг тодорхойлсон чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах тусгай хууль, эрх зүйн баримт бичгүүдийг 1920-иод оноос батлан олон арга хэмжээг хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, 1970 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг батлан гаргасан байдаг. Энэ хуулийн соёлын дурсгалт зүйлийн төрөлд "...соёлын түүх, дурсгалын холбогдолтой гэрэл зураг, соронзон хальс, пянз, кино зургийн хальс зэрэг зүйлс"-ийг оруулжээ.

Мөн Монгол Улсын Засгийн газраас 1994 онд Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль, 2001 онд Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2014, 2021 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулж батлахад гэрэл зургийг соёлын өвийн биет дурсгалд оруулсан байдаг.

Соёлын өвийг хамгаалах хуулийн 3 дугаар бүлгийн 1.4-ийн Түүх соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад "сурвалж бичиг, гар бичмэл, барын болон хэвлэмэл ном судар, аман зохиол зэрэг бичгийн дурсгал, гэрэл зураг, кино болон дүрс бичлэг багтана" гэж гэрэл зургийг түүхэн дурсгалт зүйлийн жагсаалтад оруулсан байдаг.

Эдгээр хуульд гэрэл зургийг соёлын өвийн дурсгалд оруулж өгсөн нь гэрэл зургийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн ихээхэн тустай зүйл болсон байна.

Монгол Улсын төр засгаас гэрэл зургийг хөгжүүлэхэд тал бүрээр анхаарч, тусгайлсан тогтоол, шийдвэрийг удаа дараа гаргаж байсан нь гэрэл зургийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Засгийн газраас гаргасан тушаал, тогтоол, шийдвэрүүд нь гэрэл зургийн газрын үйл ажиллагааг сайжруулах, улс орон даяар гэрэл зургийн үйл ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн гэрэл зурагчдыг системтэй бэлтгэхэд түлхэц өгчээ.

Мөн төрөөс авсан арга хэмжээ нь гэрэл зургийн үндсэн материал эх негативыг хадгалах хамгаалах, ангийн төрөлжүүлэх, архивын дүрэм журмын дагуу эмхлэх, цэгцлэх, гэрэл зургийн хадгалалт, гэрэл зургийн бүртгэлийг сайжруулахад чухал ач холбогдолтой болжээ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хуулиуд хийгээд, тушаалуудыг эмхэтгэн хавсарсан сэтгүүл. (1935). №4 (81)., УБ.
2. Бүх Монголын хувьсгалт залуучуудын төлөөлөгч нарын хоёрдугаар их хурлын тогтоол (Б. №1). (1923). УБ.
3. Гэгээрэл, шинжлэх ухаан, соёлын талаар холбогдолтой хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл (1961-1963). (1964). УБ, БНМАУ, УБ.
4. (1967). МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэр (1921-1966). УБ.
5. Монгол кино зургийн хорооны дүрэм. (1936.). “Ардын үндэсний эрх” сонин, №104.
6. Монгол улсын үндэсний төв архив. (1956). Улс төрийн, нам олон нийтийн байгууллагын баримтын архив. Монгол улсын үндэсний төв архив.
7. Улс төрийн, нам олон нийтийн байгууллагын баримтын архив. (1956). УБ: Монгол улсын үндэсний төв архив.
8. Улс төрийн, нам олон нийтийн байгууллагын баримтын архив. (1923). УБ: Монгол улсын үндэсний төв архив.
9. Х.Дамдин. (1977). Гэрэл зураг-эрин үеийн толь. Соёл сэтгүүл, 13.

Summary

Recent publications of archives reveal that since the declaration of Mongolia's autonomy and subsequently the Mongolian People's Republic the authorities then in power attached a special attention and supported through policies the formation and development of a sector of photography. This study aims at a comparative analysis

and systematic approach of regulatory acts and decisions regarding the genesis of photography, eventually on photojournalism in Mongolia. The government meticulously tracked and supported setting up a framework for photography and its application and any use as it was considered an important media tool for ideological purposes mainly and solely at that time. However, this policy played a primary role for the initial educating and training national photographers and technicians, setting up an institutional base of photography agency and spreading photography services for commoners.

For the purposes of tracking and resurrecting the historical chronology and impact of regulatory acts from first few photographer's stores to photojournalism in national mass media, the research covered most of available acts and publications on ruling political party and its affiliating public associations, government decisions, statutes and legal instructions in area of science, education and culture, newspaper and magazine editions and, where available, home security departments, as the state control in photography sector was immense and conscientious.

The study is to fulfill a gap in photography history and understanding the further ways for photography and in particular photojournalism from a retrospective point of view and assist photojournalists be fair and objective in their public duties.

Keywords: photojournalism, photographer, historical photo, electric shadow, photographer.